



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/353

Мөрөн сум

Барилгын буулгалтын ажил хүлээж авах
комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24, 35 дугаар зүйлийн 35.1.2, 48 дугаар зүйлийн 48.1, 48.6, Засгийн газрын 2021 оны 212 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 8-р багт Уурын зуух буулгах ажлыг хүлээж авах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Б.Энхжаргал (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Х.Даваасүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Ерөнхий архитектор)

Ж.Жавзанпагма (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

Д.Оюун-Эрдэнэ ("Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв" ОНӨААТҮГ газрын ерөнхий инженер)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

Д.Сүхбат ("Хөх Монгол констракшн" ХХК-ийн захирал)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

Д.Сүхээ (Хөвсгөл Ус суваг ХХК-ийн ерөнхий инженер)

Ц.Бэхбаяр (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

Комиссын нарийн бичгийн дарга:

Б.Баасанжав (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)


2. Буулгалтын ажлыг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн дотор зохион байгуулж ажиллахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Буулгалтын ажлыг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Б.Баасанжав) -д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилгын ажил хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР